



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 14 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/100/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дархан-Уул аймаг

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:

Утас: 70378845

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 70373089

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Ч.Гантулга

Утас: 99372297

Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

дэд.од.рх № 128
танай _____ -ны № _____ -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН
14 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
М.САНЖАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын 14 дүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 14 дүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хичээлийн А байрны 86,7 м² вакум цонхыг 38,223.5 мянган төгрөгөөр, Б байрны 460 м² дээврийн их засварыг 61,641.6 мянган төгрөгөөр засварлажээ.

Мөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 8,120.0 мянган төгрөгийн 4 ш компьютер, 1,400.0 мянган төгрөгийн 2 ш самбар, 7,255.0 мянган төгрөгийн гал тогооны тавилга, тоног төхөөрөмжийг тус тус хүлээн авч, санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 200,652.8 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 14.8 хувиар өссөн байна.

4526050072

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 14 дүгээр сургуулийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 52 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 92 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр аймгийн Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	222,263,434.68	320,390,020.06
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	94,736,059.13	54,544,059.61
312	Банкинд байгаа	94,736,059.13	54,544,059.61
3121	Төгрөг	94,736,059.13	54,544,059.61
31211	Төрийн сангийн харилцах	94,736,059.13	54,544,059.61
35	БАРАА МАТЕРИАЛ	127,527,375.55	265,845,960.45
351	Түүхий эд материал	78,000.00	78,000.00
35130	Эм боох материал	78,000.00	78,000.00
354	Хангамжийн материал	127,449,375.55	265,767,960.45
35410	Бичиг хэргийн материал	1,715,870.00	1,469,870.00
35420	Аж ахуйн материал	36,786,910.55	32,383,106.55
35450	Барилгын засварын материал	10,672,250.00	17,654,250.00
35460	Хүнсний материал	1,853,130.00	7,300,395.00
35470	Бусад хангамжийн материал	76,421,215.00	206,960,338.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,766,859,273.86	3,020,612,252.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,766,859,273.86	3,020,612,252.74
392	Биет хөрөнгийн дүн	2,727,197,273.86	2,980,950,252.74
39201	Барилга байгууламж	2,616,203,240.00	2,955,035,496.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(393,773,486.03)	(464,080,691.99)
39205	Машин тоног төхөөрөмж	499,941,357.56	564,025,574.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(244,141,630.76)	(312,859,271.60)
39207	Тавилга, эд хогшил	344,382,577.41	345,213,826.41
39208	Хуримтлагдсан элэгдэл	(142,957,109.44)	(171,650,673.01)
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,479,183.87	56,918,249.87
39215	Хуримтлагдсан элэгдэл	(22,827,499.18)	(22,394,298.88)
39217	Ном	32,890,640.43	30,742,041.38
393	Биет бус хөрөнгийн дүн	39,662,000.00	39,662,000.00
39301	Программ хангамж	16,182,632.00	16,182,632.00
39302	Хасагдуулга	(16,182,632.00)	(16,182,632.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	39,662,000.00	39,662,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,989,122,708.54	3,341,002,272.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,054,400.00	2,740,300.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,054,400.00	2,740,300.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,054,400.00	2,740,300.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,987,068,308.54	3,338,261,972.80
51	Засгийн газрын хувь оролцоо	2,987,068,308.54	3,338,261,972.80
511	Засгийн газрын оруулсан капитал	382,077,381.89	382,077,381.89
512	Хуримтлагдсан үр дүн	272,047,896.21	630,698,205.47
51210	Өмнөх үеийн үр дүн	272,047,896.21	279,504,541.21
51220	Тайлант үеийн үр дүн	-	351,193,664.26
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,332,943,030.44	2,325,486,385.44
6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН	2,989,122,708.54	3,341,002,272.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,225,590,384.20	2,848,306,176.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	175,988,984.20	552,634,976.90
120	Нийтлэг татварын бус орлого	175,988,984.20	552,634,976.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	638,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,260,919.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	161,643,923.20	417,096,953.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	10,530,742.00	134,899,123.90
120009	Бусад орлого	553,400.00	-
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,049,601,400.00	2,295,671,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,667,851,400.00	1,940,471,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,667,851,400.00	1,940,471,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,400,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	18,400,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	363,350,000.00	355,200,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	363,350,000.00	355,200,000.00
2	Үйл ажиллагааны зардал	2,221,490,014.61	2,493,389,138.43
21	Урсгал зардал	2,221,490,014.61	2,493,389,138.43
210	Бараа, үйлчилгээний зардал	2,166,838,728.81	2,433,332,665.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,353,128,518.70	1,561,023,370.55
210101	Үндсэн цалин	892,969,247.03	927,344,532.98
210102	Нэмэгдэл цалин	413,054,871.67	568,638,804.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	8,056,200.00
210104	Урамшуулал	47,104,400.00	56,983,833.20
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	166,204,562.67	195,351,155.93
210201	Тэтгэврийн даатгалын	113,476,914.18	133,906,891.01
210202	тэтгэмжийн даатгалын	13,287,738.14	15,613,290.25
210203	ҮОМШӨ-ий даатгалын	6,685,981.24	8,082,724.47
210204	Ажилгүйдлийн даатгалын	6,534,056.18	7,693,365.93
210205	ЭМ-ийн даатгалын	26,219,872.93	30,054,884.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	324,439,964.20	323,431,148.69
210301	Гэрэл цахилгааны зардал	16,004,525.20	23,204,986.34
210302	Түлш халаалтын зардал	283,618,624.00	283,618,626.90
210303	Цэвэр бохир усны зардал	24,816,815.00	16,607,535.45
2104	Хангамж, бараа материалын зардал	41,530,536.20	4,681,504.00
210401	Бичиг хэргийн зардал	9,649,300.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31,881,236.20	-
210408	Бараа материал акталсны зардал	-	4,681,504.00
2105	Нормативт зардал	63,987,518.00	100,941,549.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	320,000.00	-
210502	Хоол, хүнс	63,667,518.00	100,941,549.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,733,700.00	13,568,940.00

210604	Урсгал засварын зардал	8,733,700.00	13,568,940.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	21,738,503.97	18,548,477.24
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	553,400.00	-
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	21,185,103.97	18,548,477.24
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	187,075,425.07	215,786,519.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,821,005.50	32,047,639.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	519,650.00	7,273,280.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	167,734,769.57	176,465,599.91
213	Урсгал шилжүүлэг	54,651,285.80	60,056,473.31
	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	41,998,750.00	41,879,262.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,652,535.80	18,177,211.31
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,652,535.80	18,177,211.31
3	Үйл ажиллагааны үр дүн	4,100,369.59	354,917,038.47
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн	5,201,283.72	3,723,374.21
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,201,283.72	3,723,374.21
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,201,283.72	3,723,374.21
4	Үйл ажиллагааны бус үр дүн	(5,201,283.72)	(3,723,374.21)
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	(1,100,914.13)	351,193,664.26

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,050,189,800.00	2,296,740,366.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	588,400.00	638,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	588,400.00	638,900.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	588,400.00	638,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	638,900.00
120009	Бусад орлого	588,400.00	-
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,049,601,400.00	2,296,101,466.84
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,667,851,400.00	1,940,471,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,667,851,400.00	1,940,471,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,400,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	18,400,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	363,350,000.00	355,200,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	363,350,000.00	355,200,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	430,266.84
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		430,266.84
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,059,895,681.74	2,319,657,099.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,059,895,681.74	2,319,657,099.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,012,623,954.44	2,258,918,908.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,352,396,884.60	1,561,023,370.55
210101	Үндсэн цалин	892,237,612.93	927,344,532.98
210102	Нэмэгдэл	413,054,871.67	568,638,804.37
210103	Хоол унаа хөнгөлөлт		8,056,200.00
210104	Урамшуулал	47,104,400.00	56,983,833.20
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,204,562.67	195,351,155.93
210201	Тэтгэврийн даатгалын	113,476,914.18	133,906,891.01
210202	Тэтгэмжийн даатгалын	13,287,738.14	15,613,290.25
210203	ҮОМШӨ-ий даатгалын	6,685,981.24	8,082,724.47
210204	Ажилгүйдлийн даатгалын	6,534,056.18	7,693,365.93
210205	Эрүүл мэндийн даатгалын	26,219,872.93	30,054,884.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	324,439,964.20	323,431,148.69
210301	Гэрэл цахилгааны зардал	16,004,525.20	23,204,986.34
210302	Түлш, халаалтын зардал	283,618,624.00	283,618,627.61
210303	Цэвэр бохир усны зардал	24,816,815.00	16,607,534.74
2105	Нормативт зардал	69,760,406.50	105,935,096.00
210502	Хоол, хүнс	69,760,406.50	105,935,096.00
2106	Эд хогшил урсгал засвар	26,292,500.00	13,591,640.00
210604	Урсгал засвар	26,292,500.00	13,591,640.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	21,738,503.97	18,548,477.24
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	553,400.00	
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	21,185,103.97	18,548,477.24
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,791,132.50	41,038,019.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,265,195.50	33,453,929.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	11,525,937.00	7,584,090.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,271,727.30	60,738,191.31
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	34,619,191.50	42,560,980.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,652,535.80	18,177,211.31
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,652,535.80	18,177,211.31
22	Хөрөнгийн зардал	29,676,710.00	16,845,000.00
2220	Дотоод эх үүсвэрээр	29,676,710.00	16,845,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,676,710.00	16,845,000.00
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(9,705,881.74)	(22,916,732.68)
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(29,676,710.00)	(16,845,000.00)
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(39,382,591.74)	39,761,732.68
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	134,118,650.87	94,736,059.13
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	94,736,059.13	54,544,059.61

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	<i>/төгрөгөөр/</i>			
	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
A	1	2	3	4
2024 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	382,077,381.89	2,332,943,030.44	272,047,896.21	2,988,169,222.67
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
ҮХ-ийн өсөлт, бууралт	-	-	-	-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,100,914.13)	(1,100,914.13)
2025 оны 01 дүгээр сарын 01-нээрх үлдэгдэл	382,077,381.89	2,332,943,030.44	272,047,896.21	2,987,068,308.54
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	7,456,645.00	7,456,645.00
ҮХ-ийн өсөлт, бууралт	-	-	-	-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт	-	(7,456,645.00)	-	(7,456,645.00)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	351,193,664.26	351,193,664.26
2025 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	382,077,381.89	2,325,486,385.44	630,698,205.47	3,338,261,972.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	2,294,071,900.00	2,277,493,988.69	(16,577,911.31)	99.3
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,938,871,900.00	1,938,871,900.00	-	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,938,871,900.00	1,938,871,900.00	-	100
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	355,200,000.00	337,022,788.69	(18,177,211.31)	94.9
132001	Орон нутгийн төсвөөс	355,200,000.00	337,022,788.69	(18,177,211.31)	94.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	94,736,059.13	638,900.00	(94,097,159.13)	0.67
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	638,900.00	638,900.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	94,736,059.13	-	(94,736,059.13)	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,388,807,959.13	2,278,132,888.69	(110,675,070.44)	95.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,442,758,560.89	2,318,324,888.21	(124,433,672.68)	94.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,382,432,560.89	2,257,586,696.90	(124,845,863.99)	94.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,612,306,500.00	1,561,023,370.55	(51,283,129.45)	96.8
210101	Үндсэн цалин	1,022,014,100.00	927,344,532.98	(94,669,567.02)	90.7
210102	Нэмэгдэл	566,545,300.00	568,638,804.37	2,093,504.37	100
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	8,056,200.00	8,056,200.00	-
210104	Урамшуулал	23,747,100.00	56,983,833.20	33,236,733.20	240
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	201,538,200.00	195,351,155.93	(6,187,044.07)	96.9
210201	Тэтгэврийн даатгал	137,046,000.00	133,906,891.01	(3,139,108.99)	97.7
210202	Тэтгэмжийн даатгал	16,123,100.00	15,613,290.25	(509,809.75)	96.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,061,500.00	8,082,724.47	21,224.47	100
210204	Ажилгүйдлийн даатгал	8,061,500.00	7,693,365.93	(368,134.07)	95.4
210205	Эрүүл мэндийн даатгал	32,246,100.00	30,054,884.27	(2,191,215.73)	93.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	358,134,460.89	323,431,148.69	(34,703,312.20)	90.3
210301	Гэрэл, цахилгаан	24,589,446.44	23,204,986.34	(1,384,460.10)	94.4
210302	Түлш, халаалт	303,577,328.45	283,618,627.61	(19,958,700.84)	93.4
210303	Цэвэр, бохир ус	29,967,686.00	16,607,534.74	(13,360,151.26)	55.4
2104	Хангамж, бараа материалын зардал	-	18,177,211.31	18,177,211.31	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	18,177,211.31	18,177,211.31	-
2105	Нормативт зардал	117,103,300.00	105,935,096.00	(11,168,204.00)	90.5
210502	Хоол, хүнс	117,103,300.00	105,935,096.00	(11,168,204.00)	90.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,600,000.00	13,591,640.00	(8,360.00)	99.9
210604	Урсгал засвар	13,600,000.00	13,591,640.00	(8,360.00)	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,795,600.00	18,548,477.24	(3,247,122.76)	85.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,795,600.00	18,548,477.24	(3,247,122.76)	85.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,954,500.00	57,883,019.80	(71,480.20)	99.9

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,370,400.00	50,298,929.00	(71,471.00)	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,584,100.00	7,584,090.80	(9.20)	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,326,000.00	60,738,191.31	412,191.31	101
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,326,000.00	42,560,980.00	(17,765,020.00)	70.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	60,326,000.00	42,560,980.00	(17,765,020.00)	70.6
223001	Бусад хөрөнгө		16,845,000.00	16,845,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		16,845,000.00	16,845,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2,442,758,560.89	2,318,324,888.21	(124,433,672.68)	94.9
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		94,736,059.13	94,736,059.13	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		54,544,059.61	54,544,059.61	
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	52	51	(1.00)	98.1
6	Удирдах ажилтан	1	1	-	100
7	Гүйцэтгэх ажилтан	37	37	-	100
9	Гэрээт ажилтан	14	13	(1.00)	92.9

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 14 дүгээр сургуулийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийж нийт 6,735.9 мянган төгрөгийн залруулга илрүүлж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 1,272.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 2,316.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг 100 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	2	-	100
Албан шаардлага	1	2,316.0	1	2,316.0	100
Төлбөрийн акт	2	1,272.0	2	1,272.0	100
Нийт дүн	5	3,588.0	5	3,588.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,899.2 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж, аудитын явцад залруулав. Үүнд:

- Тайланд онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 6,735.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн, санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангуудын уялдаа холбоог шалгахад 16,163.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн зарчим" 5.1.4. "үнэн зөв байх" заалт, УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", санхүүгийн тайлангийн аудитын "Ангилал", "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул үндсэн хөрөнгө дансанд бүртгэж, санхүүгийн тайлангуудын алдааг залруулав.

Мөн аудитаар нийт 16,848.8 мянган төгрөгийн зөрчил² илэрсэн тул төсөвт буцаан төвлөрүүлэх 600.0 мянган төгрөгийн акт, 16,248.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Илрүүлэлт: Тус сургуулийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч М.Санжаагийн сургалтын төлбөрт 600.0 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам"-ын хавсралт "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар"-ын 3-д "Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1.Илрүүлэлт: Тус сургуулийн захирал М.Санжаа нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,262.8 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна", 27.6-д "Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В хэсэгт "Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2.Илрүүлэлт: Тус сургуулийн сургалтын менежер, нийгмийн ажилтан, дотуур байрны багш нарт улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тооцож, нийт 12,427.0 төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-д "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай", Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.8-д "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.3.Илрүүлэлт: Тус сургуулийн нягтлан бодогч С.Удвалд Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, сургуулийн захирлын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/53 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн

цалин 1,559.0 төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-т "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай", "Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.8-д "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмж байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тус сургууль нь 10 нэр төрлийн 6,735.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.	1	6,735.9	-	-	-	-	1	6,735.9	-	-	-	-
Санхүүгийн байдлын тайлан, үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн хоорондын уялдаа 16,163,282.00 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	16,163.3	-	-	-	-	-	16,163.3	-	-	-	-
Дүн	1	22,899.2	-	-	-	-	1	22,899.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны	Тоо	Дүн
Тус сургуулийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч М.Санжаагийн сургалтын төлбөрт 600,000.00 төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	600.0	1	600.0	-	-	-	-	-	-	-	-
Тус сургуулийн захирал М.Санжаа нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,262,800.00 төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.	1	2,262.8	-	-	1	2,262.8	-	-	-	-	-	-

Тус сургуулийн нягтлан бодогч С.Удвалд Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, сургуулийн захирлын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/53 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн цалин 1,559,000.00 төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна.	1	1,559.0	-	-	1	1,559.0	-	-	-	-	-	-
Тус сургуулийн сургалтын менежер, нийгмийн ажилтан, дотуур байрны багш нарт улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тооцож, нийт 12,427,010,00 төгрөгийг олгосон байна.	1	12,427.0	-	-	1	12,427.0	-	-	-	-	-	-
Дүн	4	16,848.8	1	600.0	1	16,248.8	-	-	-	-	-	-